



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** АХГ-2022/24/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор:

Ц.Наранчимэг Утас: 261663

Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж

Утас: 51-261628 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ

Утас: 261628 Цахим хаяг: [bolor-erdened@audit.gov.mn](mailto:bolor-erdened@audit.gov.mn)

Аудитор: Д.Эрдэнэчимэг

Утас: 260512 Цахим хаяг: [erdenechimegda@audit.gov.mn](mailto:erdenechimegda@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
8. Аудитын илрүүлэлт.....	17
8.1 Залруулсан алдаа .....	17
8.3 Албан шаардлага .....	17
8.4 Зөвлөмж.....	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

---

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ О.БАТНАСАН ТАНАА

2022.03.15 № 07/620

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 1,264.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монголын төмөр зам ТӨХК тайлант онд нийт 22,922.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 22,764.7 сая төгрөгийн зардал гарган, 157.8 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 24,481.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 24,260.3 сая төгрөгийг зарцуулж, 220.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

## Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

## Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 93 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. Р. Ц. НАРАНЧИМЭГ*



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	22,696,146,242.49	1,385,203,241.62
1.1.2	Дансны авлага	1,247,762,283.54	2,397,242,562.59
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	21,018,174,251.77	38,755,244,759.03
1.1.4	Бусад авлага	33,091,549.76	25,491,050.00
1.1.5	Бараа материал	882,312,500,252.08	46,885,077,033.07
1.1.6	Урьдчилж төлсөн зардал тооцоо	151,396,981,285.94	122,148,138,437.13
1.1.7	Бусад эргэлтийн хөрөнгө	2,623,490,735.56	-
1.1.8	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,081,328,146,601.14</b>	<b>211,596,397,083.44</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	268,709,507,711.41	256,725,629,504.14
1.2.2	Дуусаагүй барилга	-	1,088,439,593,274.70
1.2.3	Биет бус хөрөнгө	63,637,424.21	72,738,384.72
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	463,229,130,557.48	693,767,529,201.48
1.2.5	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	6,882,114,047.18
1.2.6	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>732,002,275,693.10</b>	<b>2,045,887,604,412.22</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,813,330,422,294.24</b>	<b>2,257,484,001,495.66</b>
2.1.1.1	Дансны өглөг	100,519,242,892.51	45,992,378,381.80
2.1.1.2	Татварын өр	19,611,847.49	42,762,367.16
2.1.1.3	Хүүний өглөг	16,551,284,316.83	-
2.1.1.4	Урьдчилж орсон орлого	-	928,994,992.40
2.1.1.5	Бусад богино хугацаат өр төлбөр	33,164,543,420.20	43,494,143,214.19
2.1.1.6	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>150,254,682,477.04</b>	<b>90,458,278,955.55</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	287,087,917,793.98	277,994,630,142.15
2.1.2.2	Бусад урт хугацаат өр төлбөр	882,950,000,000.00	1,153,405,301,440.00
2.1.2.3	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,170,037,917,793.98</b>	<b>1,431,399,931,582.15</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,320,292,600,271.02</b>	<b>1,521,858,210,537.70</b>
2.3.1	Төрийн өмч	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	139,351,735.55	139,351,735.55
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	537,038,125,023.88	767,576,523,667.88
2.3.4	Хуримтлагдсан ашиг	(64,867,313,250.81)	(52,817,742,960.07)
2.3.5	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>493,037,822,023.22</b>	<b>735,625,790,957.96</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>1,813,330,422,294.24</b>	<b>2,257,484,001,495.66</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>5,977,425,911.88</b>	<b>4,341,314,615.78</b>
2	Борлуулалтын өртөг	4,411,422,575.01	4,181,675,865.39
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>1,566,003,336.87</b>	<b>159,638,750.39</b>
4	Түрээсийн орлого	11,208,353,622.93	20,035,805,806.96
5	Хүүгийн орлого	2,983,892,216.40	104,004,686.84
6	Ерөнхий ба удирдлагын зардал	8,287,723,237.22	15,155,013,347.39
7	Санхүүгийн зардал	2,425,901,962.87	4,924,823,556.48
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,419,561,666.76)	(178,847,926.90)
9	Бусад ашиг (алдагдал)	36,065,718.76	215,516,723.10
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>661,128,028.11</b>	<b>256,281,136.52</b>
11	Орлогын татварын зардал	298,389,221.63	35,510,791.08
12	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>362,738,806.48</b>	<b>220,770,345.44</b>
13	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>362,738,806.48</b>	<b>220,770,345.44</b>
14	<b>Орлогын нийт дүн</b>	<b>362,738,806.48</b>	<b>220,770,345.44</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,727,658,514.60</b>	<b>767,531,557,001.08</b>	<b>(64,643,103,032.29)</b>	<b>723,755,464,218.94</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>20,727,658,514.60</b>	<b>767,531,557,001.08</b>	<b>(64,643,103,032.29)</b>	<b>723,755,464,218.94</b>
Өмчид гаргасан өөрчлөлт	-	(230,493,431,977.20)	(53,639,025.00)	(230,547,071,002.20)
Зарласан ногдол ашиг	-	-	(533,310,000.00)	(533,310,000.00)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	362,738,806.48	362,738,806.48
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,727,658,514.60</b>	<b>537,038,125,023.88</b>	<b>(64,867,313,250.81)</b>	<b>493,037,822,023.22</b>
Өмчид гаргасан өөрчлөлт	-	230,538,398,644.00	11,865,073,825.30	242,403,472,469.30
Зарласан ногдол ашиг	-	-	(36,273,880.00)	(36,273,880.00)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	220,770,345.44	220,770,345.44
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,727,658,514.60</b>	<b>767,576,523,667.88</b>	<b>(52,817,742,960.07)</b>	<b>735,625,790,957.96</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>18,899,542,277.28</b>	<b>18,184,107,952.21</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,557,085,985.96	17,855,169,662.86
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	41,018,734.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	342,456,291.32	287,919,555.35
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>14,211,660,089.74</b>	<b>21,649,076,943.81</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,514,438,851.51	5,812,942,529.51
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,301,922,605.50	1,749,540,610.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,486,847,446.56	1,292,056,753.49
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	131,633,007.64	70,243,093.26
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	261,638,568.69	943,270,464.72
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	5,132,903,352.93	9,315,875,268.66
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,351,491,452.14	915,020,039.62
1.2.9	Бусад мөнгөн зарлага	30,784,804.77	1,550,128,184.51
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>4,687,882,187.54</b>	<b>(3,464,968,991.60)</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,983,892,216.40</b>	<b>104,004,686.84</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,983,892,216.40	104,004,686.84
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>672,271,044,993.87</b>	<b>279,096,633,132.05</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	672,267,644,993.87	6,831,943,974.23
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	3,400,000.00	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	272,104,689,157.82
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	160,000,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(669,287,152,777.47)</b>	<b>(278,992,628,445.21)</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>526,973,693,553.21</b>	<b>270,455,571,385.43</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	526,950,000,000.00	270,455,301,440.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	23,693,553.21	269,945.43
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>533,889,357.58</b>	<b>9,308,916,949.49</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	9,271,696,645.78
3.2.4	Төлсөн ногдол ашиг	533,310,000.00	36,273,880.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	579,357.58	946,423.71
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>526,439,804,195.63</b>	<b>261,146,654,435.94</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(138,159,466,394.30)</b>	<b>(21,310,943,000.87)</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	160,855,612,636.79	22,696,146,242.49
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>22,696,146,242.49</b>	<b>1,385,203,241.62</b>

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	2020 оны Гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>20,210,527.0</b>	<b>22,922,535.0</b>	<b>24,481,125.0</b>	<b>1,558,590.0</b>	<b>7.0</b>
2	<b>Нийт зардал</b>	<b>15,129,837.0</b>	<b>22,764,747.0</b>	<b>24,261,513.0</b>	<b>1,496,766.0</b>	<b>7.0</b>
2.1	<i>Ерөнхий ба удирдлагын зардал</i>	<i>3,736,578.0</i>	<i>4,591,494.0</i>	<i>3,757,929.0</i>	<i>(833,565.0)</i>	<i>(18.0)</i>
3	Үндсэн үйл ажиллагааны ашиг	5,080,690.0	157,788.0	219,612.0	61,824.0	39.0
4	Ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	(4,419,562.0)		(178,848.0)	(178,848.0)	
5	Нийт ашиг алдагдал	661,128.0	157,788.0	40,764.0	(117,024.0)	(74.0)
6	Бусад ашиг алдагдал			215,517.0	215,517.0	
7	Орлогын албан татвар	298,389.0	15,779.0	35,511.0	19,732.0	125.0
8	Цэвэр ашиг (алдагдал)	362,739.0	142,009.0	220,770.0	78,761.0	55.0
9	Төсвийн төлбөрт нийт дүн	2,515,119.0	1,485,719.0	3,935,717.0	2,449,998.0	165.0
10	Төрийн өмчийн ногдол ашиг	533,310.0	28,402.0	36,274.0	7,872.0	28.0
11	Нийт ажиллагсдын тоо	225.0	304.0	284.0	(20.0)	(7.0)
12	Нийт цалингийн сан	2,516,895.0	3,080,801.0	4,069,723.0	988,922.0	32.0
13	Нэг ажилтны дундаж цалин	1,575.39.0	1,665.0	1,665.0	-	0.0
14	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	0.7	0.9	0.9	(0.0)	0.0
15	Хөрөнгө оруулалт	429,579.0	27,090,752.0	5,535,666.0	(21,555,086.0)	(80.0)
16	Нийт авлага	1,280,854.0	1,132,304.0	2,422,734.0	1,290,430.0	114.0
17	Нийт өглөг	1,320,292,600.0	1,792,786,138.0	1,521,858,211.0	(270,927,927.0)	(15.0)
17.1	Урт хугацаат өр төлбөр	1,170,037,918.0	1,775,004,098.0	1,431,399,932.0	(343,604,166.0)	(19.0)
17.2	Богино хугацаат өр төлбөр	150,254,682.0	17,782,040.0	90,458,279.0	72,676,239.0	409.0
18	Тавантолгой-Зүүн баян төслийг санхүүжүүлэх үнэт цаас борлуулсны төлбөр	882,950,000.0	1,484,104,010.0	1,360,445,642.0	(123,658,368.0)	(8.0)
19	БНХАУ-ын Эксим банк, Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлийн төлбөр	287,087,918.0	287,816,390.0	277,994,630.0	(9,821,760.0)	(3.0)
20	"Шинэ төмөр зам" төсөл болон шинээр баригдах төмөр замын судалгаа хөгжүүлэлтийн зардал	-	600,000.0	-	(600,000)	(100.0)
21	Тавантолгой-Зүүн баян төслийн менежментийн зардал	6,819,253.0	5,649,063.0	6,408,060	758,997	13.0
22	Тавантолгой-Зүүн баян төслийн хөрөнгө оруулалтын зардал	1,876,685.0	276,525.0	45,027	(231,498)	(84.0)

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад түрээсийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 05-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитор Д.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/167 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзсэн.

Монголын төмөр зам ТӨХК-ийн дотоод аудитын алба нь зорилтот түвшний гүйцэтгэл, үндсэн үйл ажиллагаанд аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаагүй, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг холбогдох стандартад нийцсэн боловч Төмөр замын салбартай холбоотой үйлдвэрлэлийн шат дамжлага бүрд өдөр тутам гарч буй хөрөнгийн хөдөлгөөнийг баримтжуулах, бүртгэх, хүлээн зөвшөөрөх, хөрөнгийн тооллого хийж баталгаажуулах, хяналт тавих болон урт хугацаат хөрөнгө оруулалт, хувьцаа эзэмших эрхийн талаар өөрийн онцлогт тохирсон асуудлуудыг тусгаагүй байна.

Дотоод аудитын алба нь 2 орон тоотойгоор батлагдсан боловч 1 орон тоо дутуу ажиллаж байна.

Дотоод аудитын төлөвлөгөөнд 5 ажил төлөвлөж, 14 чиглэлээр хяналт шалгалт хийж хөрөнгийн тооллогоор нийт 7 төрлийн 237.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, эд хогшил дутсан, хүнсний худалдан авалтын төсвийг 36.1 сая төгрөгөөр хэтрүүлсэн зэрэг нийт 273.9 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлсэн боловч акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 24,261.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 242.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Монголын төмөр зам ТӨХК-ийн зорилго нь төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг эрхлэх, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг угсрах, засварлах, түрээслэх, суурь бүтцийг засварлах арчлах хууль тогтоомжоор хориглоогүй орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагаа эрхлэх зорилго бүхий Төрийн өмчит хувьцаат компани юм.

Төмөр замын тээврийн тухай хууль болон компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;
- Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг угсрах, засварлах, түрээслэх, суурь бүтцийг засварлах, арчлах түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй орлого ашгаа нэмэгдүүлэхэд чиглэсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх;
- Компани нь дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг өөрийн салбар болон охин компани байгуулан гүйцэтгэх;
- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа үйл ажиллагааг эхлүүлнэ;
- Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хуулийн этгээдийн статустай, 100 хувийн төрийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газар байх бөгөөд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Монголын төмөр зам ТӨХК-ийг Засгийн газрын 2008 оны 82 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2008 оны 189 дүгээр тогтоолоор байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах гэсэн зүйл заалттай нийцэж байна.

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөл, бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасантай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Зам, тээврийн хөгжлийн яам зэрэг хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 3, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллаж байна.

Тайлант онд 9 удаагийн хурал зохион байгуулж 2021 оны бизнес төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөө, "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр зам барих төслийн захиргаа, удирдлагын зардлын задаргаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тус тус хэлэлцэн баталсан байна. Үүнд:

- Аудитын хорооны санал дүгнэлтийн тухай;
- Ногдол ашгийн тухай;
- Гүйцэтгэх захирлын контракт гэрээг дүгнэх тухай;
- Дэд захирлыг зөвшилцөх тухай;
- Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжтэй танилцах болон бусад чиглэлийн асуудлуудыг хянан шийдвэрлэж, холбогдох газруудад үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах;
- Тайлант онд төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын зардалд 102.8 сая, НДШ-ийн зардалд 13.4 сая, тээвэр шатахуун, шуудан холбооны зардалд 5.5 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд хөрөнгө хариуцсан ажилтнуудтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулах, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын чиглэлийн дагуу гүйцэтгэх захирал компанийн өдөр тутмын үйл ажиллагааг ханган ажиллах арга хэмжээг авч ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;
- ТӨБЗГ-ын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоол.

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	22,696,146.2	1,385,203.2	21,310,943.0
Авлага	22,299,028.1	41,177,978.4	18,878,950.3
Урьдчилж төлсөн зардал тооцоо	151,396,981.3	122,148,138.4	(29,248,842.8)
Бараа материал	882,312,500.3	46,885,077.0	(835,427,423.2)
Бусад эргэлтийн хөрөнгө	2,623,490.7	0.0	(2,623,490.7)
Үндсэн хөрөнгө	268,773,145.1	256,798,367.9	(11,974,777.2)

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Дуусаагүй барилга	0.0	1,088,439,593.3	1,088,439,593.3
Урт хугацаат хөрөнгө оруулалт	463,229,130.6	693,767,529.2	230,538,398.6
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.0	6,882,114.0	6,882,114.0
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,813,330,422.3</b>	<b>2,257,484,001.5</b>	<b>444,153,579.2</b>
Богино хугацаат өр төлбөрийн дүн	150,254,682.5	<b>90,458,278.9</b>	<b>59,796,403.6</b>
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,170,037,917.8	1,431,399,931.6	261,362,013.8
Эздийн өмчийн дүн	493,037,822.0	735,625,791.0	242,587,968.9
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>1,813,330,422.3</b>	<b>2,257,484,001.5</b>	<b>444,153,579.2</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, дуусаагүй барилга, урт хугацаат хөрөнгө оруулалт, өр төлбөр, эздийн өмчийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,385.2 сая төгрөг болж, 21,310.9 сая төгрөгөөр буурсан нь “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн ажил эрчимжиж, оны эхний үлдэгдлээс гэрээт ажлын гүйцэтгэлд зарцуулсантай холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл 38,755.2 сая төгрөг болж, 17,737.0 сая төгрөгөөр өссөн нь Тавантолгой-Зүүн баян чиглэлийн төмөр зам барих төслийн гэрээт ажлын худалдан авалтын НӨАТ-ын авлагаас голлон шалтгаалсан;
- Авлага дансны үлдэгдэлд хугацаандаа байгаа 1,908.2 сая төгрөгийн авлага, 2015-2020 онуудад үүссэн 2-5 жилийн насжилттай, хууль хяналтын байгууллагаар шийдэгдэх 512.7 сая төгрөгийн авлага;
- Урьдчилгаа данс 122,148.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Таван толгой-Зүүн баян чиглэлийн төмөр зам барих төслийн урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй 118,921.4 сая төгрөгийн гэрээт ажлын гүйцэтгэл хангагдаагүй, 15.8 сая төгрөгийн барилгын зураг төсөл зохиох ажлын гүйцэтгэлийг хангаагүй байгаа нь нийт үлдэгдлийн 97.3 хувийг эзэлж байна.

Дээрх үлдэгдлээс Тавантолгой-Гашуунсухайт төслийн хүрээнд 2013 онд Эко Геодро Гео ХХК-тай геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэлийн урьдчилгаа төлбөрт 2,683.5 сая төгрөгийн санхүүжилтийг 2013, 2014 онуудад Монгол улсын хөгжлийн банкаар дамжуулан хийсэн байна. Эко Геодро Гео ХХК нь үлдэгдэл төлбөр барагдуулах талаар Монголын төмөр зам ТӨХК-ийг шүүхэд өгсөн байна. Мөн Байгаль орчны нарийвчилсан судалгааны ажил гүйцэтгэсэн Найчрал Састайнэблэ ХХК-ийн гэрээний гүйцэтгэлийн 518.7 сая төгрөгийн төлбөрийг 2013 онд Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан хийсэн байна.

Монгол Улсын Хөгжлийн банкаар санхүүжигдсэн төслүүд 2015 оноос эхлэн зогссоноос шалтгаалан эдгээр 2 байгууллагын санхүүжилтийн гүйцэтгэл урьдчилгаа дансанд бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,885.0 сая төгрөг болж, 835,427.4 сая төгрөгөөр буурсан нь Таван толгой-Зүүн баян чиглэлийн төмөр зам барих төслийн гэрээт ажлын гүйцэтгэлийг дуусаагүй үйлдвэрлэл данснаас компанийн захирлын 2021 оны А/85 дугаар тушаалыг үндэслэн залруулах бичилт хийж дуусаагүй барилга дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд бараа материалын дансанд дараах материаллаг хэмжээний өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийн ажлын дээд бүтэц барих материалын 392,257.6 сая, замын доод бүтцийн далан, гүүр, хоолойн ажил, геодези

судалгааны ажил, цахилгаан эрчим хүч, худаг, барилга байгууламж зэрэг 652,033.1 сая, нийт 1,044,290.7 сая төгрөгийн ажлыг дуусаагүй үйлдвэрлэлийн данснаас дуусаагүй барилга дансанд бүртгэсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 256,798.3 сая төгрөг болж, 11,974.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 1,790.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, 9,423.3 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан, ТӨБЗГ-ын 2020 оны А-1/2381 дүгээр тогтоолоор 45 ширхэг 54,029.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан зэргээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 72.7 сая төгрөг болж, 9.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 26.3 сая төгрөгийн өртөгтэй Таван толгой-Зүүн баян чиглэлийн төмөр замын төслийн тухай /40 минутын/ баримтат кино бүтээж бүртгэлд тусгасан нь нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 90,458.2 сая төгрөг болж, 59,796.4 сая төгрөгөөр буурсан нь Таван толгой-Зүүн баян төслийн гэрээт ажлын гүйцэтгэлийн өглөгийг тооцоо нийлсэн актыг үндэслэн аж ахуйн нэгж байгууллагуудад олгож, Сангийн яамтай дамжуулан зээлийн гэрээний хэрэгжилтийг үнэлэн хуримтлуулан бүртгэсэн зээлийн хүү 12,121.0 сая төгрөгийг залруулан бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Урт хугацаат зээлийн үлдэгдэл 277,994.6 сая төгрөг болж, 9,093.3 сая төгрөгөөр буурсан нь БНХАУ-ын Экспорт импортын банкнаас "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх төсөл"-ийн хүрээнд зээлээр худалдан авсан машин, механизмын өр төлбөр, Азийн хөгжлийн банкны Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн зээлийн төлбөрт нийт 9,271.7 сая төгрөгийг төлсөн нь нөлөөлсөн байна.

Зээлийн төлөлт нь уг хөрөнгийг эзэмших талаар Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хурлын 02 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр 57 дугаар тогтоолоор тус тус шийдвэр гарч, зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлтэй холбоотойгоор Сангийн сайд болон Зам тээврийн сайд нар 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр дамжуулан зээлдүүлэх Б/ЗГ-21/24-24/02 дугаар бүхий нэмэлт гэрээг байгуулснаар хэрэгжиж эхэлсэн байна.

Бусад урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,153,405.0 сая төгрөг болж, 270,455.0 сая төгрөгөөр өссөн нь Эрдэнэс таван толгой компанид төлөх Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийн тайлант оны санхүүжилтийн дүнгээр нэмэгдсэн байна.

Монгол Улсын Засгийн Газар ба БНХАУ-тай байгуулсан "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх төсөл"-ийн үндсэн дээр нэмж бүртгэсэн 85,602.9 сая төгрөгийн зээл нь Монголын төмөр зам ТӨХК-ийн төлбөрийн чадварыг бууруулж, цаашид компанийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, ханшийн зөрүүний өөрчлөлтөөс алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 735,625.8 сая төгрөг болж, 242,587.9 сая төгрөгөөр өссөн нь Гүйцэтгэх захирлын "Хөрөнгө оруулалтын бүртгэл залруулах тухай" А/85 тоот тушаалыг үндэслэн хийсэн залруулга, ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам барих төслийн 230,493.4 сая төгрөгийн төмөр замын зурвас газрыг "Таван толгой төмөр зам" ХХК-д шилжүүлсэнтэй холбоотой залруулга хийж эзний өмчийн хэсэгт нэмж бүртгэсэн, 2020 оны 36.3 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төлсөн, өмнөх онд хуримтлагдсан хүүгийн зардлыг өглөгөөр бүртгэж 12,483.6 сая төгрөгийг залруулж бүртгэснээс шалтгаалжээ.

Эздийн өмч дэх төрийн өмчийн дансны үлдэгдэлд бүртгэлтэй 207,277,000 ширхэг, 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хувьцааны нийт үнэ 20,727.7 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 139.4 сая төгрөг бөгөөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2020 оны 682 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 22,922.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 22,764.7 сая төгрөгөөр, 157.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 27,090.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 24,481.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 24,260.3 сая төгрөгийг зарцуулж, 220.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Тайлант онд нийт орлогын гүйцэтгэл 24,481.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,558.6 сая төгрөгөөр давж биелсэн, нийт зардлын гүйцэтгэл 24,261.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,496.8 сая төгрөг буюу 7.0 хувиар илүү зарцуулсан байна. Зардлыг төлөвлөснөөс 1,496.8 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь гүйцэтгэх захирлын "Компанийн салбар байгуулах тухай" 2021 оны А/71 дүгээр тушаал батлагдсаны дагуу төмөр замын зам, барилгын механикжсан ангийг тусад нь байгуулж Таван толгой-Зүүнбаян төслийн төмөр замын дээд үе угсрах ажлын гүйцэтгэх орон тоо, цалингийн зардал, машин техник ажиллуулсны түрээсийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 24 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээр санхүүжих 5,535.5 сая төгрөгийн худалдан авалтыг санхүүжүүлсэн. Тайлант хугацаанд 100 ш вагон авахаар төсөвлөж 30 ш хагас вагоны төлбөрт 5,245.6 сая төгрөг төлсөн байна.

Тайлант онд цэвэр ашиг 220.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 78.7 сая төгрөгөөр илүү байгаа нь ханшийн зөрүүний алдагдал 178.7 сая, бусад ашиг 215.5 сая, орлогын албан татварын зардал 35.5 сая төгрөгийг төлсөн нь нөлөөлжээ.

ТӨБЗГ-ын 2021 оны 228 дугаар тогтоол, мөн оны А-1/1108 дугаар албан бичгийн дагуу тайлант онд 36.8 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т бүрэн төвлөрүүлсэн.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 140 мэдээлэл оруулахаас 5.6 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам" 29 дүгээр тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөх



## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монголын төмөр зам ТӨХК-ийн засаглал, үйл ажиллагаанд нөлөөлөхүйц дараах шийдвэр гарсан байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоол, 2019 оны 304 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар тогтоолоор 693,763.5 сая төгрөгийн хөрөнгийг Тавантолгой төмөр зам ХХК-ийг үүсгэн байгуулах үед шилжүүлэн хөрөнгө оруулалтыг хийсэн ба Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолоор тус компанийн 66.0 хувийг Эрдэнэс-Тавантолгой ХК-д, 34 хувийг Монголын төмөр зам ТӨХК-д эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн нийт төсөвт өртөг нь 1,300,000.0 сая төгрөг бөгөөд Монголын төмөр зам ТӨХК-аас тус төсөлд 750,000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн ба Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолоор Зүүнбаян төмөр зам ХХК-ийг үүсгэн байгуулж, тус компанийн нийт хувьцааны 66.0 хувийг Эрдэнэс-Тавантолгой ХК, 34.0 хувийг Монголын төмөр зам ТӨХК эзэмших, цаашид Зүүнбаян төмөр зам ХХК-ийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дээрх шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгээс үзэхэд Монголын төмөр зам ТӨХК нь Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор Таван толгой төмөр зам ХХК-ийн хувьцааны 34.0 хувийг эзэмшихээр 693,767.5 сая төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалт хийсэн. Мөн Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоол, 2020 оны Засгийн газрын 117 дугаар тогтоолын дагуу 750,000.0 сая төгрөгийн бонд гарган хувьцаа эзэмшиж байгаа боловч 2 компаниас эзэмшсэн хувьцаа, бондын хэмжээнд үр ашиг хүртээгүй, эзэмшил тодорхойгүй байгаа нь Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т "Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотолно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн засаглалыг сайжруулж, хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг хэрэгжүүлж, эзэмшлийн хувийг тодорхой болгох талаар холбогдох газарт хандан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөх

## 6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 26,889.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 681.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 23,168.5 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 3,039.6 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилтийг шалгахад төлбөрийн актын биелэлт 50 хувь, албан шаардлагын биелэлт 100 хувь, зөвлөмжийн биелэлт 83.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	681,086.1	1	371,086.1	1	310,000.0	50.0
Албан шаардлага	5	23,168,500.0	5	23,168,500.0	-	-	100
Зөвлөмж	10	3,039,600.0	9	2,819,700.0	1	219,900.0	83.8
<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>26,889,300.0</b>	<b>15</b>	<b>26,359,400.0</b>	<b>2</b>	<b>529,900.0</b>	<b>77.9</b>

Өмнөх онд тогтоосон Логистикийн төвийн түрээсийн орлого 310.0 сая төгрөгийн төлбөрийн актыг төвлөрүүлээгүй нь Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүгчийн 2021 оны 7943 дугаар захирамжаар захиргааны хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаатай холбоотой байна.

Мөн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд бэлтгэсэн бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 219.9 сая төгрөгийн үнэ бүхий арматурын төмөр

дутагдсан зөрчлийг Өмнөговь аймгийн Цагдаагийн байгууллага 6 жил үргэлжлүүлэн шалгаж байгаа боловч шийдвэрлэгдээгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар туршилтын тээвэр эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд 6 багц 40 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө гарган ажиллаж, 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 88.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд аудит хийж гүйцэтгэх аудитын сэдвийг баталсны дагуу Таван толгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд 2022 оны 3 дугаар улиралд гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Татварын ерөнхий газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017-2021 оны дуусталх хугацааны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд тус компанийн хүсэлтээр татварын хяналт шалгалтыг 2021 онд хийж НӨАТ төлөөгүй зөрчилд 45,675.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулж, төлж тайлагнаагүй зөрчилд улсын байцаагчийн НА-21210000065 тоот акт тус тус тогтоосон байна. Дээрх улсын байцаагчийн актыг хүлээн зөвшөөрөхгүй Татварын ерөнхий газрын маргаан таслах зөвлөлд хандсан үндэслэлээр НӨАТ-ын авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгааг дараагийн аудитаар шалгах нь зүйтэй.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 69,079.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 67,814.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 512.7 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 752.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1,264.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 242.6 сая төгрөгөөс хэтэрсэн тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой мөнгөн гүйлгээний тайланд данс хооронд шилжүүлсэн давхардсан гүйлгээг дутуу цэвэрлэснээс үндсэн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг 67,814.5 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.

### 8.3 Албан шаардлага

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан экспортын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжсэн "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд тус компани нь Сангийн яам, Зам, тээвэр хөгжлийн яам хооронд 2019, 2021 онуудад дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулснаар үндсэн болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу төлж эхэлсэн ба зээлийн эргэн төлөлтөд ашиглаж эхлэхээс өмнөх хугацаанд хуримтлагдсан хүүг төлсөн нь Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн 282.4-т "Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээг байгуулсанд тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", ТӨБЗГ-ын 2021 оны 57 дугаар тогтоолын 1 дүгээр заалтад "... дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу ашиглаж эхэлсэн хугацаанаас хойших холбогдох зардлыг тооцож бүртгэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгөхөөс өмнөх хугацааны хуримтлагдсан хүү төлсөн зөрчлийг холбогдох дээд шатны байгуулагад хандаж шийдвэрлүүлэн, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

2. Түрээсийн 3 сарын урьдчилгааг харилцах дансанд байршуулаагүй 14 түрээслэгчтэй холбоотой нийт 2,397.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 512.7 сая төгрөгийн олон

жилийн насжилттай авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээслэгчдээс түрээсийн гэрээнд заасны дагуу 3 сарын урьдчилгаа хөрөнгийг байршуулах заалтыг хэрэгжүүлж, олон жилийн насжилттай авлагын үлдэгдлийг барагдуулах албан шаардлага хүргүүлэх.

3. 2019 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа Монголын төмөр зам ТӨХК-ийн охин компани Монголиа порт групп ХХК-ийн 2,787.6 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй санхүүгийн тайланг толгой компанийн санхүүгийн тайланд нэгтгэж тайлагнаагүй байгаа нь Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Охин компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах ба толгой компани нь охин компанитайгаа нэгдсэн санхүүгийн тайлан гаргана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг нэгтгэж тайлагнах албан шаардлага хүргүүлэх

4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 219.9 сая төгрөгийн бараа, материал алдагдсан зөрчлийг арилган, эзэн холбогдогчоор төлүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх

#### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Монголын төмөр зам ТӨХК нь УБТЗ ХНН-тэй түрээсийн гэрээ байгуулан Замын-Үүд дэх шилжүүлэн ачих цогцолборыг түрээслүүлэн тайлант хугацаанд гэрээний төлбөрт 3,185.8 сая төгрөгийн орлого хуримтлуулан хүлээн авсан боловч 5,330.0 сая төгрөгийн зардал гарч нийт 2,144.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн өөрийн хөрөнгө түрээслүүлэх журмын 3-т "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: УБТЗ ХНН-тэй байгуулсан түрээсийн гэрээний төлбөрийг нэмэгдүүлж, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх

## 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй өмчлөгчийн улсын бүртгэлийн гэрчилгээгүй Замын -Үүд сум дахь ШАЦ-1 орон сууцны 752.2 сая төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг цогцолбор барилгын эзэмшил тодорхойгүй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас шилжүүлэх тухай журмын 4.1.4-т *“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ”*, Нягтлан бодох бүргэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн эзэмшлийг тодорхой болгож, улсын бүртгэлийн гэрчилгээтэй болгох, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах

**Илрүүлэлт:** МТЗ ТӨХК-ийн Төмөртэй өртөөний барилга, төмөр зам нь 2016 онд ашиглалтад орж тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа боловч тус өртөөний 16 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үнэ тодорхойгүй, төмөр замууд санхүүгийн тайланд бүртгэлгүй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас шилжүүлэх журмын 4.1.4-т *“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ”*, Нягтлан бодох бүргэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн гэрчилгээг бүрдүүлж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

**Илрүүлэлт:** МТЗ ТӨХК-ийн үндсэн хөрөнгийн тайланд техникийн гэрчилгээгүй 66,008.0 сая төгрөгийн үнэ бүхий 9 ширхэг машин механизм, эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээгүй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас шилжүүлэх журмын 4.1.4-т *“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ”*, Нягтлан бодох бүргэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн гэрчилгээг бүрдүүлж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

**Илрүүлэлт:** МТЗ ТӨХК нь Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд байршилтай 72.4 сая төгрөгийн үнэ бүхий 2000 м.кв талбайтай газар байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас шилжүүлэх журмын 4.1.4-т *“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ”*, Нягтлан бодох бүргэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн гэрчилгээг бүрдүүлж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой мөнгөн гүйлгээний тайланд данс хооронд шилжүүлсэн давхардсан гүйлгээг дутуу цэвэрлэснээс үндсэн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг 67,814,539.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	Залруулга	1	67,814,539.1	1	67,814,539.1	-	-	-	-	-	-	-	
2	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	Монголын төмөр зам ТӨХК нь УБТЗ ХНН-тэй түрээсийн гэрээ байгуулан Замын-Үүд дэх шилжүүлэн ачих цогцолборыг түрээслүүлэн тайлант хугацаанд гэрээний төлбөрт 3,185,831.0 мянган төгрөгийн орлого хуримтлуулан хүлээн авсан боловч 5,330,264.0 мянган төгрөгийн зардал гарч нийт 2,144,433.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	Хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	
3	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	Түрээсийн 3 сарын урьдчилгааг харилцах дансанд байршуулаагүй 14 түрээслэгчтэй холбоотой нийт 2,397,242.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс 512,700.0 мянган төгрөгийн олон жилийн насжилттай авлага байна.	Урьдчилгаа төлбөрийг байршуулж, авлага барагдуулах албан шаардлага	1	512,700.0	-	-	-	-	1	512,700.0	-	-	-	
4	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	МУЗГ, БНХАУ-ын ЗГ хооронд байгуулсан экспортын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжсэн "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд тус компани нь Сангийн яамтай 2019, 2021 онуудад дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан ба зээлийн эргэн төлөлтөд	Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, хүүг дараа төлбөрт суутган тооцох албан шаардлага	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

			зээлийг ашиглаж эхлэхээс өмнөх хугацааны хүүг хуримтлуулан төлсөн байна.															
5	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй өмчлөгчийн улсын бүртгэлийн гэрчилгээгүй Замын -Үүд сум дахь ШАЦ-1 орон сууцны 752,151.2 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг цогцолбор барилгын эзэмшил тодорхойгүй байна.	Хөрөнгийн эзэмшлийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж	1	752,151.2	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	752,151.2
6	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн дансанд эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээгүй Өмнеговь аймгийн Баян-Овоо суманд байршилтай 72.4 сая төгрөгийн үнэ бүхий 2000 м.кв талбайтай газар бүртгэлтэй байна.	Хөрөнгийн УБГ гаргуулах зөвлөмж	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
7	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн дансанд техникийн гэрчилгээгүй 2020 онд төслийн хүрээнд бэлтгэсэн 66,008,622.0 мянган төгрөгийн үнэ бүхий 9 ширхэг машин механизм бүртгэлтэй байна.	Техникийн гэрчилгээг бүрдүүлэх зөвлөмж	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
8	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	МТЗ ТӨХК-ийн Төмөртэй өртөөний барилга, төмөр зам нь 2016 онд ашиглалтад орж тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа боловч тус өртөөний 16 нэр төрлийн үнэ өртөг тодорхойгүй үндсэн хөрөнгө, төмөр замууд санхүүгийн тайланд бүртгэлгүй байна.	Хөрөнгийг бүртгэн, хяналт тавьж ажиллах зөвлөмж	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
9	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	2019 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа Монголын төмөр зам ТӨХК-ийн охин компани Монголиа порт групп ХХК-ийн 2,787,636.4 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэй санхүүгийн тайланг толгой компанийн санхүүгийн тайланд нэгтгэж тайлагнаагүй байна	Тайланг нэгтгэх албан шаардлага	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
10	МТЗ ТӨХК	АХГ-2022/24/НА-СТА-ТӨА	Өмнөх оны аудитын 219,900.0 мянган төгрөгийн бараа, материал алдагдсан зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
<b>ДҮН</b>					<b>10</b>	<b>69,079,390.3</b>	<b>1</b>	<b>67,814,539.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>512,700.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>752,151.2</b>		

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	МТЗ ТӨХК	АХГ- 2022/24/НА- СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 140 мэдээлэл оруулахаас 5,602.9 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмж	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	
2	МТЗ ТӨХК	АХГ- 2022/24/НА- СТА-ТӨА	МТЗ ТӨХК нь ЗГ-ын 2018 оны 242 дугаар тогтоол, ЗГ-ын 2019 оны 304 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор Таван толгой төмөр зам ХХК-ийн хувьцааны 34 хувийг эзэмшихээр балансаас баланст 693,767,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн урт хугацаат хөрөнгө оруулалт болон эзний өмчийн бусад хэсэгт бүртгэсэн. Мөн ЗГ-ын 2019 оны 135 дугаар тогтоол, 2020 оны ЗГ-ын 117 дугаар тогтоолын дагуу 750,000,000.0 мянган төгрөгийн бонд гарган Зүүн баян төмөр зам ХХК-ийн хувьцааны 34 хувийг эзэмшүүлэх шийдвэр гарсны дагуу баланст урт хугацаат зээлийн өглөгөөр бүртгэн хувьцаа эзэмшиж байгаа боловч дээрх 2 компаниас эзэмшсэн хувьцаа, бондын хэмжээнд үр ашиг хүртээгүй, эзэмшил тодорхойгүй байна.	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж, засаглалыг сайжруулах зөвлөмж	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	
<b>ДҮН</b>					<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	
<b>НИЙТ ДҮН</b>					<b>12</b>	<b>69,079,390.3</b>	<b>1</b>	<b>67,814,539.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>512,700.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>752,151.2</b>





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 543/А0160067  
АХГ-2022/24/НА-СТА-Т0А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын төмөр зам ТӨХК-ийн охин компани Монголиа порт групп ХХК нь 2019 онос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд нийт 2,787,636,435.00 төгрөгийн хөрөнгөтэй санхүүгийн тайланг, толгой компанийн санхүүгийн тайланд нэгтгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Охин компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах ба толгой компани нь охин компанитайгаа нэгдсэн санхүүгийн тайлан гаргана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Монголиа порт групп ХХК-ийн санхүүгийн тайланг нэгтгэж тайлагнах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал О.Батнасан, ерөнхий нягтлан бодогч Ц.Баатарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ӨРДЭНЭЧИМЭГ

0001081434



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 544/А 0160064  
АХГ-2020/24/КА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түрээсийн 3 сарын урьдчилгааг харилцах дансанд байршуулаагүй 14 түрээслэгчтэй холбоотой нийт 2,397,242,562.00 төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэлтэй байгаагаас 512,731,154.00 төгрөгийн олон жилийн насжилттай авлага байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


- Олон жилийн насжилттай авлагын үлдэгдлийг барагдуулж, зөрчлийг арилгах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал О.Батнасан, ерөнхий нягтлан бодогч Ц.Баатарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

0001081432



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 545/А0160064  
АХГ-2022/04/КА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 219,900,000.00 төгрөгийн бараа материал алдагдсан зөрчлийг арилган, эзэн холбогдогчоор төлүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "бансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, бараа материал алдагдсан зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал О.Батнасан, ерөнхий нягтлан бодогч Ц.Баатарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

0001081436



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 546/А0160067

Улаанбаатар хот

АХС-2022/04/НБ-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан экспортын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд Сангийн яам, Зам, тээвэр хөгжлийн яам хооронд 2019, 2021 онуудад дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулснаар тус компани нь зээлийн эргэлт төлөлтөд ашиглаж эхлэхээс өмнөх хугацааны хуримтлагдсан хүүг төлсөн байна.

Энэ нь Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн 282.4 "Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээг байгуулсанд тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 57 дугаар тогтоолын 1 дүгээр заалтад " ... дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу ашиглаж эхэлсэн хугацаанаас хойших холбогдох зардлыг тооцож бүртгэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Үндсэн хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгөхөөс өмнөх хугацааны хуримтлагдсан хүү төлсөн зөрчлийг холбогдох дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал О.Батнасан, ерөнхий нягтлан бодогч Ц.Баатарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ар, хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-714230

9019120396

\\jg-10-10-30\Bichig\_Kherog\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-225.Docx

0001081430